

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2025/141/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.selenge@audit.gov.mn](http://www.selenge@audit.gov.mn)

Сүхбаатар сум  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: [enkhtuyach@audit.gov.mn](mailto:enkhtuyach@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: [batmunkhb@audit.gov.mn](mailto:batmunkhb@audit.gov.mn)

Аудитыг гүйцэтгэсэн: "Пийк Ом аудит" ХХК

Утас: 99052418 Цахим хаяг: [cheegii9989@gmail.com](mailto:cheegii9989@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	11
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	13
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв:.....	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2. Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОУБ	Олон улсын байгууллага



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨӨ СУМЫН БУГАНТ ТОСГОНЫ  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
П.ДАВААЖАРГАЛ ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/141/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд тус сургууль нь аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 107,356.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 28 зорилтын хүрээнд 119 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 96.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	253,535,116.17	240,804,317.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	218,469,242.01	186,616,982.88
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	218,469,242.01	186,616,982.88
3121	Төгрөг	218,469,242.01	186,616,982.88
31211	Төрийн сангийн харилцах	218,469,242.01	186,616,982.88
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА		
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	35,065,874.16	54,187,334.86
354	Хангамжийн материал	35,065,874.16	54,187,334.86
3542	Аж ахуйн материал	3,044,700.00	3,044,700.00
3547	Бусад хангамжийн материал	32,021,174.16	51,142,634.86
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	884,666,856.55	1,037,970,976.55
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	884,666,856.55	1,037,970,976.55
392	Биет хөрөнгө	852,386,256.55	1,005,690,376.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	613,151,801.20	613,151,801.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-127,942,104.96	-132,204,041.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,708,333.36	-10,517,361.14
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	240,425,527.49	390,904,797.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-84,020,592.10	-84,774,341.78
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	152,441,129.06	162,957,599.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,183,451.99	-42,274,918.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,583,900.00	5,094,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,069,678.60	-3,674,621.22
39216	Дуусаагүй барилга, байгууламж	53,843,324.00	53,843,324.00
39217	Ном	37,302,235.81	38,621,139.11
393	Биет бус хөрөнгө	32,280,600.00	32,280,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,280,600.00	32,280,600.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,138,201,972.72	1,278,775,294.29
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
413	Өглөг		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,138,201,972.72	1,278,775,294.29
51	Засгийн газрын хувь оролцоо	1,138,201,972.72	1,278,775,294.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	335,538,988.20	335,538,988.20

51101	Өмч: - төрийн	335,538,988.20	335,538,988.20
512	Хуримтлагдсан үр дүн	-167,820,448.82	-27,247,127.25
5121	Өмнөх үеийн үр дүн	-167,820,448.82	-167,820,448.82
5122	Тайлант үеийн үр дүн		140,573,321.57
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	970,483,433.34	970,483,433.34
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,138,201,972.72	1,278,775,294.29

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,466,735,193.46	1,845,284,260.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	175,338,878.87	161,245,647.70
120	Нийтлэг татварын бус орлого	175,338,878.87	161,245,647.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	66,513,512.40	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,696,378.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	61,817,134.40	
120009	Бусад орлого		10,000,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	92,339,869.00	140,913,548.30
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	16,485,497.47	10,332,099.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,291,396,314.59	1,684,038,612.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,050,706,700.00	1,465,764,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,050,706,700.00	1,465,764,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,043,400.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,043,400.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,646,214.59	218,273,812.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,646,214.59	218,273,812.33
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,330,471,034.10	1,704,710,938.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,330,471,034.10	1,704,710,938.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,257,935,834.10	1,631,818,638.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	774,075,413.67	1,168,311,479.15
210101	Үндсэн цалин	574,051,207.40	716,507,620.57
210102	Нэмэгдэл	166,748,187.41	392,845,441.38

210104	Урамшуулал	33,276,018.86	58,958,417.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,756,340.44	147,441,619.19
210201	Тэтгэврийн даатгал	68,095,587.91	100,768,041.39
210202	Тэтгэмжийн даатгал	8,010,809.01	11,802,912.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,270,047.14	5,883,469.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,434.56	5,785,148.68
210205	Эрүүл мэндийн даатгал	14,895,461.82	23,202,047.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,753,614.59	210,381,212.33
210301	Гэрэл, цахилгаан	7,324,532.59	9,375,892.33
210302	Түлш, халаалт	188,429,082.00	167,300,320.00
210303	Цэвэр, бохир ус	20,000,000.00	33,705,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,113,860.00	4,872,838.70
210404	Ном, хэвлэл	9,113,860.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		4,872,838.70
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,652,100.00	17,287,565.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,175,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,477,000.00	17,287,565.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	143,691,905.40	75,631,323.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,544,922.75	42,544,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,933,278.00	12,629,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	100,213,704.65	20,457,423.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,535,200.00	72,892,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,535,200.00	72,892,300.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,457,000.00	65,563,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,078,200.00	7,329,000.00
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	136,264,159.36	140,573,321.57
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	136,264,159.36	140,573,321.57

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,296,092,692.59	1,694,038,612.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,696,378.00	10,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,696,378.00	10,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,696,378.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,696,378.00	
120009	Бусад орлого		10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,291,396,314.59	1,684,038,612.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,050,706,700.00	1,465,764,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,050,706,700.00	1,465,764,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,043,400.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	17,043,400.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	223,646,214.59	218,273,812.33
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	223,646,214.59	218,273,812.33
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,264,408,186.70	1,693,042,876.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,264,408,186.70	1,693,042,876.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,191,872,986.70	1,620,096,976.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	774,075,413.67	1,168,311,479.15
210101	Үндсэн цалин	574,051,207.40	716,507,620.57
210102	Нэмэгдэл	166,748,187.41	392,845,441.38
210104	Урамшуулал	33,276,018.86	58,958,417.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,756,340.44	147,441,619.19
210201	Тэтгэврийн даатгал	68,095,587.91	100,768,041.39
210202	Тэтгэмжийн даатгал	8,010,809.01	11,802,912.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,270,047.14	5,883,469.47
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,434.56	5,785,148.68
210205	Эрүүл мэндийн даатгал	14,895,461.82	23,202,047.25
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	215,753,614.59	210,381,212.33
210301	Гэрэл, цахилгаан	7,324,532.59	9,375,892.33
210302	Түлш, халаалт	188,429,082.00	167,300,320.00
210303	Цэвэр, бохир ус	20,000,000.00	33,705,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00
210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,696,800.00	17,287,565.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,175,100.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,521,700.00	17,287,565.79
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,698,218.00	68,782,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,764,940.00	55,153,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,933,278.00	13,629,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,535,200.00	72,945,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	72,535,200.00	72,945,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	61,457,000.00	65,563,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,078,200.00	7,382,600.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	31,684,505.89	995,735.87
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		32,847,995.00
	Дотоод эх үүсвэрээр		32,847,995.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		32,847,995.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-32,847,995.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	31,684,505.89	-31,852,259.13
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		218,469,242.01
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		186,616,982.88

## 2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	-167,820,448.82	1,138,201,972.72
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
17	Тайлант үеийн үр дүн			140,573,321.57	140,573,321.57
19	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	-27,247,127.25	1,278,775,294.29

## 2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,915,057,000.00	1,725,890,871.46	189,166,128.54	90.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,915,057,000.00	1,693,042,876.46	222,014,123.54	88.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,833,412,400.00	1,620,096,976.46	213,315,423.54	88.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,317,776,000.00	1,168,311,479.15	149,464,520.85	88.7
210101	Үндсэн цалин	830,139,800.00	716,507,620.57	113,632,179.43	86.3
210102	Нэмэгдэл	444,354,000.00	392,845,441.38	51,508,558.62	88.4
210104	Урамшуулал	43,282,200.00	58,958,417.20	-15,676,217.20	136.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,722,000.00	147,441,619.19	17,280,380.81	89.5
210201	Тэтгэврийн даатгал	112,011,000.00	100,768,041.39	11,242,958.61	90.0
210202	Тэтгэмжийн даатгал	13,177,800.00	11,802,912.40	1,374,887.60	89.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,588,900.00	5,883,469.47	705,430.53	89.3
210204	Ажилгүйдлийн даатгал	6,588,900.00	5,785,148.68	803,751.32	87.8
210205	Эрүүл мэндийн даатгал	26,355,400.00	23,202,047.25	3,153,352.75	88.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,436,800.00	210,381,212.33	55,587.67	100.0
210301	Гэрэл, цахилгаан	9,431,500.00	9,375,892.33	55,607.67	99.4
210302	Түлш, халаалт	167,300,300.00	167,300,320.00	-20	100.0
210303	Цэвэр, бохир ус	33,705,000.00	33,705,000.00		100.0
2104	Хангамж, бараа материалын зардал				
2105	Нормативт зардал				
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00		100.0

210604	Урсгал засвар	7,892,600.00	7,892,600.00		100.0
2107	Томилолт, зочны зардал				
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,216,200.00	17,287,565.79	14,928,634.21	53.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,216,200.00	17,287,565.79	14,928,634.21	53.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	100,368,800.00	68,782,500.00	31,586,300.00	68.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,717,900.00	55,153,100.00	31,564,800.00	63.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,650,900.00	13,629,400.00	21,500.00	99.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,644,600.00	72,945,900.00	8,698,700.00	89.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,644,600.00	72,945,900.00	8,698,700.00	89.4
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,262,000.00	65,563,300.00	8,698,700.00	88.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,382,600.00	7,382,600.00		100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		32,847,995.00	-32,847,995.00	
	Дотоод эх үүсвэрээр		32,847,995.00	-32,847,995.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,915,057,000.00	1,694,038,612.33	2,498,700.00	99.9
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,468,263,500.00	1,465,764,800.00	2,498,700.00	99.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,468,263,500.00	1,465,764,800.00	2,498,700.00	99.8
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	218,519,687.67			
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	10,000,000.00		
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	218,273,812.33	218,273,812.33		100.0
132001	Орон нутгийн төсвөөс	218,273,812.33	218,273,812.33		100.0
133	ТӨСВИЙН ЗАХИРАГЧДААС				
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ				
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС				
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		218,469,242.01	-	218,469,242.01
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		186,616,982.88	-	186,616,982.88
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
6	Удирдах ажилтан		1	-1	
7	Гүйцэтгэх ажилтан		32	-32	
8	Үйлчлэх ажилтан		16	-16	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хамтын оролцоонд тулгуурлан, хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжиж, эерэг харилцаа хандлагатай бүтээлч хамт олон болох” гэсэн зорилт тавин ажиллаж байна. Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш нэг бүр өөрийгөө хөгжүүлж, сургалтын аргазүйг оновчтой сонгон ур чадвараа дээшлүүлэхэд үеийн багаар хамтран ажиллах;

- Уншаад ойлгох чадварыг хичээл судлагдахуун бүрээр дэмжин, идэвхтэй сургалтын аргуудыг сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж хэвших;
- “Нэгдүгээрт хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлж хүүхдийн хөгжил хамгааллыг хичээлээс гадуурх үйл ажиллагааг дэмжих;
- Байгууллагын соёлыг төлөвшүүлэх;
- Сурагчдад эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд эцэг эхийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;

### 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### 3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 140,573.3 мянган төгрөгөөр буюу 11.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

<i>/мянган төгрөг/</i>			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	218,469.2	186,617.0	(31,852.3)
Авлага			
Бараа материал	35,065.9	54,187.3	19,121.5
Үндсэн хөрөнгө	884,666.9	1,037,971.0	153,304.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,138,202.0</b>	<b>1,278,775.3</b>	<b>140,573.3</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,138,202.0	1,278,775.3	140,573.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,138,202.0</b>	<b>1,278,775.3</b>	<b>140,573.3</b>

Дээрх хүснэгтээс үзэхэд дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 186,617.0 мянган төгрөг болж 31,852.3 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл 54,187.3 мянган төгрөг болж 19,121.5 мянган төгрөгөөр өссөн нь БШУГ-аас 10,332.0 мянган төгрөгийн ном, хичээлийн хэрэглэгдэхүүн хүлээн авч үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн, төсвийн хөрөнгөөр 123,151.8 мянган төгрөгийн худалдан авалт хийж, үйл ажиллагаанд 114,362.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,311,416.3 мянган төгрөг болж 153,825.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 32,847.9 мянган төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авч, аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 107,356.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, аймгийн Боловсролын газраас 16,155.4 мянган төгрөгийн техник хэрэгсэл, зөөврийн компьютер, ном хэрэглэгдэхүүн, “Дезерет” ОУБ-аас 17,401.7 мянган төгрөгийн тавилга эд зэрэг нийт 140,913.5 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, сумын ИТХ-ын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 140 дүгээр тогтоолын дагуу анхны өртгөө бүрэн нөхсөн 19,936.2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж данс бүртгэлээс хассан зэрэг нь нөлөөлжээ. Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 273,445.3 мянган төгрөг бөгөөд 1,037,971.0 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй байна.

### **3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд улсын төсвөөс 1,378,730.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 206,936.8 мянган төгрөг, нийт 1,585,667.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, зарцуулахаар дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг тогтмол зардлыг 9,999.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 41,731.4 мянган төгрөгөөр, урсгал засварын зардлыг 1,392.6 мянган төгрөгөөр, тэтгэмж урамшууллын зардлыг 68,436.9 мянган төгрөгөөр нийт 121,559.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, цалин хөлс, НДШ-ийн зардлыг 54,719.5 мянган төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 19.5 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 235,260.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 12,113.6 мянган төгрөгөөр нийт 302,112.6 мянган төгрөгөөр бууруулж 1,405,115.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайланд онд төсөвт 9 удаа зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 1,468,263.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 218,329.4 мянган төгрөгийн, оны эхний

үлдэгдлээс 218,464.1 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоос 10,000.0 мянган төгрөг нийт 1,915,057.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс, НДШ-ийн зардлыг 441,404.3 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 32,216.2 мянган төгрөгөөр,
- Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 23,113.8 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 13,207.7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн гэх мэт

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,915,057.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 1,725,890.9 мянган төгрөгийг зарцуулж, 189,166.1 мянган төгрөгийг хэмнэж үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,725,890.9 мянган төгрөг буюу 90.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

<i>/мянган төгрөгөөр/</i>							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,407.4	3,407.4	-	100.0
		2	80312- Сургалт семинар	2,440.5	2,440.5	-	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	4,045.7	4,045.7	-	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	74,262.0	65,563.3	8,698.7	88.3
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	26,295.3	26,295.3	-	100.0
		6	81823- Боловсролын багшийн сургалт	11,592.3	4,688.3	6,904.0	40.4
		7	81834- Боловсролын стандарт сургалт	1,503,851.1	1,337,559.9	166,291.2	88.9
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	57,586.8	55,939.8	1,647.0	97.1
		9	81848-Сурах бичгийн түрээс	3,572.0	3,572.0	-	100.0
		10	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	1,300.2	1,278.5	21.8	98.3
		11	81875-Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	5,875.6	2,826.5	3,049.1	48.1
		12	80217-Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,498.7	-	2,498.7	-
		13	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	218,329.4	218,273.7	55.7	100.0
<b>Нийт</b>				<b>1,915,057.0</b>	<b>1,725,890.9</b>	<b>189,166.1</b>	<b>90.1</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “*Чиглэл хүргүүлэх тухай*” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, батлуулж, тайлагнаагүй, шууд худалдан авах босго үнээс давсан /2024 оны анх батлагдсан төсвөөр/ үдийн цай хөтөлбөрийн хоолны зардал 74,262.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар, нийтэд нээлттэй, ил тод зарлаж, гүйцэтгэгчийг шалгаруулалгүйгээр тухай бүр гэрээ байгуулж, худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн программ хангамжийг үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Пийк Ом Аудит” ХХК-ийн аудитор Б.Наранчимэг гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

## **4.2. Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,330,471.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,304.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль, нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл 1 удаа;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 1 удаа нийт 2 удаа хугацаа хоцроож, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг 8 удаа огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3, 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.10 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд :**

Орон нутагт хүнсний бүтээгдэхүүний бөөний төвлөрсөн цэг байхгүй, зах зээл хомс шалтгаанаар үнийн харьцуулалт хийлгүйгээр “Бугант Арвижих” ХХК, иргэн Д.Наранцэцэг нартай шууд гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.”, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоолын хавсралтын 1: “Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж зохион байгуулах зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Пийк Ом аудит “ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 908 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг тус байгууллагад хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

*/мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1				
	1				

#### 4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 6,874.8 мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан 6,419.3 мянган төгрөгийн бараа материалыг үр дүнгийн тайланд орлогоор тусгаагүй, урьд оны алдааг давтан гаргасан;
- Худалдан авсан 455.5 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалыг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээд, өөр аж ахуйн нэгжийн нэрээр орлого авсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 1,083.8 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>1</sup> илэрч 1,083.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өглөө.

##### 5.1 Төлбөрийн акт

1. Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Б/45 дугаар захирамжаар захирал П.Даваажаргалын ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “*Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “*Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Давхардуулан олгосон мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох

##### 5.2 Зөвлөмж

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг ашигласан цагаас эхлэн биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжийг биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хөрөнгийг үр дүнгийн тайланд орлогоор тусгаагүй	1	6,419.3			1	6,419.3	1	6,419.3				
Худалдан авсан хөрөнгийг төлбөр хүлээн авагчийн нэрээр бус хамаарал бүхий этгээдээс орлого авсан.	1	455.5			1	455.5	1	455.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>6,874.8</b>			<b>2</b>	<b>6,874.8</b>	<b>2</b>	<b>6,874.8</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Захиралд мөнгөн шагнал олгосон	1	1,083.8	1	1,083.8								
Нягтлан бодох бүртгэлийн CTSYSTEM 6.5 программ хангамжийг хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй	1						1					

Дүн	2	1,083.8	1	1,083.8		1					-
-----	---	---------	---	---------	--	---	--	--	--	--	---

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Шилэн дансны цахим цэсэнд 2 мэдээлэл хугацаа хоцроож, 8 мэдээллийг огт мэдээлээгүй	1						1	
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Худалдан авах ажиллагаатай холбоотой	1	-			1			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>			<b>1</b>			
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>			<b>2</b>			



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 21/А.1850385

Сүхбаатар

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн Б/45 дугаар захирамжаар захирал П.Даваажаргалын ажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь “Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 4.11 дэх “Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын гүйцэтгэл, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-т “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.3.2: Цалин хөлс, шагнал

432505761


урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урамшуулалд олгосон 1,083.8 мянган төгрөгийг Сэлэнгэ аймгийн төрийн сан дахь нэр зааж ангилагдаагүй бусад орлогын 100130000955 дугаар дансанд төвлөрүүлэх.
2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Даваажаргал, нягтлан бодогч Б.Өлзиймаа нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

**Албан шаардлага, төлбөрийн актын бүртгэл, хяналтын хуудас**

**А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл хяналт**

**1. Үндсэн мэдээлэл**

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ЕБС-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/141/НА-СТА-ТШЗ		
1.3 Аудит хийх үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит		
1.5 Албан шаардлага, төлбөрийн актын дугаар	СЭА-2025/141-НА-СТА-ТШЗ	1.6 Тогтоосон огноо	2/24/2025	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/	1,083,800.0

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Зөрчил дутагдлыг товч тодорхойлж бичих		Томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр бус сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25 ны өдрийн Б/02 дугаар захирамжаар захирал П.Даваажаргалынажлын үр дүнг үнэлж 1 сарын цалин буюу 1,083.8 мянган төгрөгийн урамшууллыг гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшуулалтай		
	Алдаа, зөрчлийн ангилал		Төлбөрийн акт		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оруулах)		Журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-т "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	Төсвийн тухай хууль		
		Заалт	6.6.2		
	Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол		
Заалт		3 дугаар хавсралт			
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Төрийн аудитын тухай хууль, МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам",			
	Заалт	Хуулийн 21.2, журмын 4.2.3, 4.2.3.3,			

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / Төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд		1,083,800.0	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд			
	Тухайн байгууллагын дансанд			
				6/15/2025

**2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл**

№	Нотлох баримтын төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Цалингийн баримт,		2024 он	
2	Сумын ЗД-ын захирамж		2024 он	

**3 Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл**

Аудитын багийн		Хариуцагч			
Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих утас
Б.Наранчимэг	Аудитор	Ерөө сумын Бугант тосгоны ЕБС	Захирал	П.Даваажаргал	99677732
			Нягтлан бодогч	Б.Өлзиймаа	94030529

**4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт**

**4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл**

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал, зөвлөмж	Гарын үсэг
1	Аудитын менежер	11/25	-	
2	Тэргүүлэх аудитор	11/25	-	

**4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл**

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор		11/25	

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Тайлбар	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2/24/2025	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Ерөө сумын Бугант тосгоны ЕБС	
		Ажилтны	Овог нэр	Б.Өлзиймаа
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Байгууллагын нэр	Пийк Ом аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөж		



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 64/А/18503/25

Сүхбаатар

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шууд худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар бус шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой ... байх зарчмыг баримтална.", Засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" 02 дугаар тогтоолын хавсралтын 1: "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-20.0 сая төгрөг" 2: "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар: Бараа-100.0 сая төгрөг" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. 4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн захирал П.Даваажаргал, нягтлан бодогч Б.Өлзиймаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР


Ч.ЭНХТУЯА

Б.НАРАНЧИМЭГ

432504190

**АЛБАН ШААРДЛАГА, ТӨЛБӨРИЙН АКТЫН БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХУУДАС**

**А. Албан шаардлага, төлбөрийн актын төсөл бэлтгэж, баталгаажуулах үеийн бүртгэл, хяналт**

1. Ерөнхий мэдээлэл

1.1 Аудитын нэр	Сэлэнгэ аймаг Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	1.2 Аудитын код	СЭА-2025/141/НА-СТА-ТШЗ
-----------------	--	-----------------	-------------------------

1.3 Аудит хийсэн үндэслэл	Төрийн аудитын тухай хуулийн 6.3.1, 8.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1	1.4 Аудитын төрөл	Санхүүгийн тайлангийн аудит
---------------------------	--	-------------------	-----------------------------

1.5 Албан шаардлага / төлбөрийн актын дугаар	СЭА-2025/141/НА-СТА-ТШЗ	1.6 Огноо	2025.02.24	1.7 Мөнгөн дүн /төгрөгөөр/
--	-------------------------	-----------	------------	----------------------------

1.8 Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл	Алдаа зөрчлийн товч утга	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс шууд худалдан авах босго үнээс давсан хүнсний материалын худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар бус шууд худалдан авах аргаар гүйцэтгэсэн зөрчлийг давтан гаргасан байна.		
	Алдаа зөрчлийн ангилал	Хууль, тогтоомж зөрчсөн		
	Журмын заалт (4.2-оос аль тохирохыг оновчлох)	4.2.1.10: "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол		
	Зөрчсөн эрх зүйн актын	Нэр	ТБОНӨХБАҮХА тухай хууль	
		Заалт	5.1	
Үндэслэл болгосон эрх зүйн актын	Нэр	Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал		
	Заалт	4.2.1.9, 4.2.1.11		

1.9 Төлбөр барагдуулах хэлбэр / төгрөгөөр/	Улсын төсвийн дансанд	1.10 Төлбөр, зөрчил барагдуулах огноо
	Орон нутгийн төсвийн дансанд	
	Тухайн байгууллагын дансанд	

2. Үндэслэл болгосон гол нотлох баримтын талаарх мэдээлэл

№	Нотлох баримтын нэр төрөл	Дугаар	Огноо	Тайлбар
1	Бараа материалын тайлан		2024 он	
2	Мөнгөн хөрөнгийн данс		2024 он	

3. Аудитын баг болон хариуцагчийн талаарх мэдээлэл

№	Аудитын багийн		Хариуцагч			
	Овог нэр	Албан тушаал	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр	Холбоо барих хаяг, утас
1	Б.Наранчимэг	Аудитор	Ерөө сумын Бугант тосгоны ЕБС	Захирал	П.Даваажаргал	99677732
				Нягтлан бодогч	Б.Өлзиймаа	94030529

4. Албан шаардлага, төлбөрийн акт бэлтгэх үеийн чанарын хяналт

4.1 Чанарын хяналт хийсэн тэмдэглэл

№	Албан тушаалтан	Огноо	Чанарын хяналтаар өгсөн санал зөвлөмж	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	2/25	-	
2	Аудитын менежер	2/25	-	

4.2 Албан шаардлага, төлбөрийн актыг хэвлэмэл хуудсанд хэвлэх зөвшөөрөл

№	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
1	Тэргүүлэх аудитор	Ч.Энхтуяа	11/25	
2				

5. Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулж, хүргүүлэх үеийн баримтжуулалт

№	Үзүүлэлт	Мэдээлэл оруулах хэсэг	Гарын үсэг	
1	Албан шаардлага, төлбөрийн актыг баталгаажуулсан тушаалын	Огноо		
		Дугаар		
2	Албан шаардлага, төлбөрийн актыг хүргүүлсэн албан бичгийн	Огноо		
		Дугаар		
3	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээлгэн өгсөн	Огноо	2025.02.24	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
4	Албан шаардлага, төлбөрийн актыг хүлээн авсан	Байгууллагын нэр	Ерөө сумынБугант тосгоны ЕБС	
		Ажилтны	Овог нэр	Б.Өлзиймаа
			Албан тушаал	Нягтлан бодогч
5	Албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтийг хариуцах	Газрын нэр	Пийк Ом Аудит ХХК	
		Ажилтны	Овог нэр	Б.Наранчимэг
			Албан тушаал	Аудитор
6	Тооцоолсон зөвшөөрүүлсэн үр өгөөж	Санхүүгийн	Тоо	
			Дүн	
		Санхүүгийн бус үр өгөөжийн тоо		